

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Чандганы нүүрсний уурхай нь Засгийн газрын 1999 оны 05-р сарын 02-ны өдрийн 74 тоот тогтоолын дагуу “Бэрх Уул” хувьцаат компанид нэгтгэснээс хойш MV-004590 тоот лицензээр олгогдсон уурхайн эдэлбэрт ашиглалт явуулж байна.

“Бэрх Уул” ХК-ийн харьяа Чандганы нүүрсний уурхай нь Хэнтий аймгийн Мөрөн суманд орших бөгөөд аймгийн төвөөс 50 км, Бэрх хотоос 130 км алслагдсан. Чандганы нүүрсний орд газар нь Цайдам нуурын нүүрсний ордод хамаарах бөгөөд орд нь Нялгын хөндийн зүүн хэсэгт орших бөгөөд Баянмөнхийн хотгорын багын хоолой буюу Шорвогийн тал гэдэг газар байрлах ба уг хоолой нь зүүн уртаашаа 100 орчим км, өргөөшөө 8-10 км талбай эзэлнэ. Цайдам нуурын ордын орших хэсэгт хоолой нь 20 км хүртэл өргөсдөг. Хотгорын захын өндөржилт уулархаг хэсгээрээ 1250-1279 м хүрнэ. Цайдам нуурын ордын нүүрс нь доод Цэрдийн Зүүн баянгийн бүрдлийн дээд подсвитын элсэн чулуу, аргиллит, алевролитын салаавчлан тогтсон чулуулгийн дунд бүрэлдэн бий болсон хүрэн нүүрсний орд юм. Тус уурхай нь Хэнтий аймгийн төв болон бусад сумуудыг нүүрсээр хангадаг ба 2021 онд хэрэглэгчдийн захиалга, аж ахуй нэгжийн гэрээг үндэслэж нүүрс бэлтгэлтийн ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. 2022 онд ковид-19 цар тахлын дэгдэлтээс хамгаалж уурхайн бүх ажилчдыг төлөвлөгөөт вакцинад хамруулан уурхайн ажлыг хэвийн тасралтгүй үргэлжлүүлэх, нийт хэрэглэгчдийг нүүрсээр хангах, уурхайн ажилчид болон бүс нутгийн хүн амыг, халдвар хамгаалалаас хамгаалан ажил үйл ажиллагаагаа явуулах гээд ихээхэн сорилтуудтай тулгарсан ч бид ажилчид нийтдээ халвар хамгаалалаа баримтлан ажилчидаа дархлаажуулалт болон вакцинад бүрэн хамруулж уурхайн үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Хүний нөөцийн хувьд инженер техникийн ажилчид болоод бусад ажилчид нийтдээ 12 хүний бүтэц бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт № 1. Уурхайд ажиллаж байгаа тоног төхөөрөмжүүд:

	Үндсэн хөрөнгийн нэр	Тоо Ажиллаж байгаа
1	Эксковатор	2
2	Бульдозер	2
3	Утгуурт ачигч	2
4	Автосамосвал	2
5	Үйлчилгээний машин	1
6	Ачааны машин	1
7	Усны машин	1
8	Түлшний машин	1

2022 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 153.0м³ хөрс хуулалтын ажил хийсэн цаашид нүүрс олборлон борлуулах ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байна. Мөн энэ онд

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

хөрс хуулалтын ажлыг хавар 5-6 сард, болон намар 9-10 сард гүйцэтгэж дууссан. Бид хөрс хуулалтын үед нийт ажилчиддаа Covid-19 халдвар авахаас хамгаалж, халдвар хамгаалалын дэглэм барьж ажилчид болон бусад хамтран ажиллагч хувь хүн, албан байгууллагуудад халдвар хамгаалалын дэглэм барин уурхайн үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Энэ жилд хуулсан 153.0м³ хөрсийг ажлын мөрөгцөгөөс дунджаар 0.8 км-т орших хуучин уурхайн карьер байсан нуур тогтсон мөргөцөг рүү зөөвөрлөн овоолго үүсгэн ажиллаж байна. Тус хөрсний овоолго нь 12-14 м-ийн өндөртэй нэг үетэй бөгөөд үүнийг гадагш тэлж талбайг өргөсгөн цаашид өмнө овоолго үүсгэсэн талбайтай нийлүүлэн овоолгыг шинээр үүсгэж байна.

Чандганы нүүрсний уурхай нь 2022 оны хөрс хуулалтын үр дүнд хөрсний овоолгын хэмжээ талбайг нэмэгдсэн боловч хөрсийг нөхөн сэргээх ажлыг ойрын жилүүдэд хийхгүй болно. Тус уурхайн нөхөн сэргээлтийн ажлын талаар 2012 онд “Абсолютмайнинг” ХХК-ийн гүйцэтгэсэн “Чандган талын нүүрсний ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэл”-д, 2017 онд “Топазиа” ХХК-ийн гүйцэтгэсэн “Чандганы уурхайн ТЭЗҮ-ийн нэмэлт тодотгол дурдсанаар 2022 оныг дуустал тус уурхайн уул геологийн нөхцөл хүчин чадал зэргийг харгалзан үзэж тухайн хугацаанд нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй гэж үзсэн байдаг. Учир нь энэ хугацаанд уурхайн гүнзгийрэлт нь хөрсний давхаргын уланд хүрэхгүй учраас нөхөн сэргээлтийн ажил цогцоор хийгдэхгүй гэж уг төслүүдэд тусгасан байна.

Чандганы нүүрсний уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголыг “Говьхангайн төгөл” ХХК боловсруулан гүйцэтгэсэн.

2022 онд Чандганы нүүрсний уурхай нь “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний хүрээнд нийт 12.06 сая төгрөгийг зарцуулахаар 13.25 сая төгрөг зарцуулан ажилласан.

**Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн
товч тодорхойлолт**

Одоогоор уулын ажлын өрнөлтийн нөлөөгөөр техтоникийн элдэв өөрчлөлт, нуруулт, гулсалт үүсээгүй байна.

1. Гал түймэр:

Уг нутаг нь гал түймрийн аюул осол ихтэй бүс нутагт хамрагдах бөгөөд хавар, намрын улиралд салхи, шуурга ихтэй байдаг учир ил задгай газарт гал гаргахаас болгоомжилж ажилласан. Хөрстэй хамт ялгагдан гарсан нүүрсний өөрийн шаталт одоогийн байдлаар гараагүй, цаашид нүүрсний давхаргын үндсэн мөргөцөгт ч өөрөө шаталт явагдах эрсдэлтэйг анхаарч ажиллаж байна.

Чандганы нүүрсний уурхай нь жил бүрийн аваар устгах төлөвлөгөөндөө галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгаж гал унтраах багаж хэрэгсэлээр хангаж ажилладаг. Мөн хөрстэй хамт ялгагдан гарсан нүүрсний хаягдал, өөрийн исэлдэлтээр шатсан нүүрс зэргийг цэвэр хөрсөөр дарах ажлыг тогтмол хийсээр ирсэн.

2. Аянга цахилгаан:

Зуны улиралд аянга цахилгааны аюул тохиолдож болох магадлалтай тул тоног төхөөрөмж болон шатахуун түгээх станц бусад барилга байгууламжид газардуулга, аянга зайлуулагч байгуулан, дээрхи зүйлүүдийн найдвартай ажиллагааг хангах талаар байнгын хяналт тавин ажиллалаа.

3. Үер усны аюул:

Хаврын улиралд цасны хайлсан шар ус, зун, намрын улиралд үргэлжилсэн буюу их устай аадар бороо орсноос шалтгаалан уурхайн ашиглалт явуулж буй талбайд их хэмжээний үерийн ус цутган орох магадлал дунд зэрэг байдаг.

Тус уурхай нь орон нутгийн чанартай уурхай тул хавар 6 сарын сүүлээс 8 сарын сүүл үе хүртэл ажиллаагүй. Тиймээс уурхайн карьерт технологийн тоног төхөөрөмж болох эксковатор, бульдозер зэрэг техникүүдийг энэ хугацаанд оруулаагүй. Иймд уг байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор уурхайн хэсэгт далан байгуулах, нуур үүсгэх, уурхайн бэлэн байдлыг хангаж ажиллахад онцгойрон анхаарсан.

Газар хөдлөлт:

Чандганы уурхайн байгууламж болон ажилчдын амьдрах байр, засварын хэсэг нь газар хөдлөлтийн аюултай бүсэд хамаарахгүй ч уурхайн болон овоолгын догол мөрөгцөгүүд хагарч нурах, гулсалт гарах аюултай тул байнгын хяналтанд байлгаж, ялангуяа хавар, намрын газрын идэвхитэй хөдөлгөөний үед уг асуудлыг хариуцсан мэргэжилтэн байнгын хяналт тавьж удирдлагыг мэдээллээр ханган ажилладаг.

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН АГУУЛГА

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

Чандган талын нүүрсний уурхайн ашиглалтын одоогийн байдал болон ашиглалт явуулах хил хязгаар, ашиглах тоног төхөөрөмж зэргийг тооцон үзэхэд амьтны аймаг, ургамлын бүрхэвч, бэлчээрт үзүүлэх онцгой хортой нөлөөлөл байхгүй.

Уурхайн орчимд гадаргын усан сүлжээ байхгүй бөгөөд уурхайн талбайгаас зүүн урдуур 22 км зайд Мөрөн гол урсдаг. Иймээс уурхайн ашиглалт олборлолтын үйл ажиллагаанаас бохирдож устаж алга болох гэх мэтээр гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй болно.

1. *Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор:* Чандганы нүүрсний уурхайн тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлж агаар дахь SO₂, NO₂, тоосжилтыг тодорхойлуулах, хяналт шинжилгээ хийлгэх, тээвэрлэлт хийх автомашинуудын хурдны хязгаарлалтын тэмдэг, тэмдэглэгээг засаж сайжруулан байршуулах, ажилчдын болон оффиссын барилгын уурын зуухны янданд шүүлтүүр тавих, ажлуудыг гүйцэтгээд байна. Мөн уурхайн карьер болон шимт хөрсний овоолго, ажилчдын байр зэрэг өмнө хийж байсан тогтсон 3 цэгт хэмжилт хийлгэн аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны лабораторид шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний үр дүн болон дүгнэлтийг тайланд хавсаргав.

Тээвэрлэлт хийх машины хурдыг хязгаарлаж, хурдны хязгаарлалтын тэмдэг тэмдэглэгээг сайжруулан, байршуулсан.

2. *Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд:* Бохир усыг стандартын шаардлага хангасан битүүмжлэл сайтай, ус нэвтрэхгүй төмөр бетон доторлогоотой тусгай бохирын цооногт хуримтдлуулдаг. Тиймээс бохирын цооногын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулсан. Мөн ажилдын ундны ус болон уурхай доторх худаг, шүүрлийн ус зэрэгээс 3 сорьц авч аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны лабораторид шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний үр дүн болон дүгнэлтийг тайланд хавсаргав.

3. *Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэрт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд:* Нефтийн бүтээгдэхүүн асгарч, орчны хөрс бохирдуулахаас сэргийлж ШТМ материалыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдахаас сэргийлэн ажилласан. Мөн засварын талбай болон засвар хийгдсэн бусад газруудад хэрэглэсэн тос, цэвэрлэх материалыг хийх тусгай савнуудыг шинэчлэн засаж, байрлуулсан.

Хөрс элэгдэл, эвдрэлд орох, үржил шимээ алдах, чийг буурах, бохирдох, гадаргын болон унаган хэлбэр өөрчлөгдөхөөс сэргийлж уурхайн эдэлбэр газарт олон салаа зам гаргахгүй, замын сүлжээг цэгцтэй болгож үйлдвэрийн технологийн замуудын эхэнд анхааруулах тэмдэг тэмдэглэгээг тавих, уурхайд ажиллах машинууд болон бусад

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

техникүүдэд шатахуунаар цэнэглэх талбай болон зориулалтын талбай зассан. Нефьт ачиж, буулгах цэг болон шимт хөрсний овоолго, уурхайн нөлөөллийн бүс зэргээс 2 сорьц авч аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны лабораторид шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний үр дүн болон дүгнэлтийг тайланд хавсаргав.

4. *Ургамлан нөмрөг хамгаалах, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах чиглэлээр:* Уурхайн бүсээс 1 ургамлын дээж авч аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны лабораторид шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний үр дүн болон дүгнэлтийг тайланд хавсаргав.

Ажилчдын байрны гадна талбайд ногоон байгууламж бий болгох зорилгоор өмнөх онуудад суулгасан улиасны тарьциас муу ургалттай моднуудыг шинэчлэн сольж, ургалт өсөлтөд нь анхааран хамгаалах торон хашаа барьж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд 2022 онд 2500ш улиас, 0.3орчим га-д суулгаж арчлан амжилттай ургуулж байна. Мөн сумын удирдлагатай хамтран ажиллах гэрээний хүрээнд сумын төвийн дэргэд ойн зурвас үүсгэн тариалалт хийж буй талбайд 2022 оны хавар 350 орчим модны буулгац авч тарьсан. Энэ ажил нь нөгөө талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан 1 тэрбум мод тарих ажилд оролцож хувь нэмэр оруулж буй ажил болно. Энэ ажилд 1 сая төгрөг зарцуулсан. Биологийн нөхөн сэргээлт хийгдэж буй талбайг хамгаалан торон хашааг үргэлжлүүлэн барьж засварлан ажиллаж байна.

Уурхайн хөдөө аж ахуйн зориулалт бүхий талбайд тарьж, туршиж буй дэрвэгэр жиргэрүү үр болон талбайд үр суулгаж буй байдал

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл



Улиас суулгаж үрслүүлж буй байдал

Тоног төхөөржүүдийн жилд хэрэглэх шатах тослох материал 100тн орчим болсон бөгөөд үүнээс үүсэх хорт хий, угааны бохирдол агаарт зохих нөлөө үзүүлдэг. Өөр химийн бодис ашиглаагүй болно.

Хүснэгт № 2. Уурхайд ажиллаж байгаа тоног төхөөрөмжүүд болон тэдгээрийн жилд ажиллах хугацаа:

№	Үндсэн хөрөнгийн нэр	Тоо Ажиллаж байгаа	Тоо Цаашид ажиллах	Жилд ажиллах хугацаа (сар)
1	Эксковатор	2	2	9
2	Бульдозер	2	2	4
3	Утгуурт ачигч	2	2	4
4	Автосамосвал	2	2	9
5	Үйлчилгээний машин	1	1	12
6	Ачааны машин	1	1	12
7	Усны машин	1	1	9
8	Түлшний машин	1	1	12

Тоног төхөөрөмжийн ажиллах хугацааг ерөнхий байдлаар харуулсан бөгөөд уулын ажлыг гүйцэтгэх, байгаль орчинд сөрөг нөлөө илүүтэй үзүүлэх экскаватор болон автосамосвалын ажиллах хугацаа нь 9-10 сар байгаа боловч энэ нь тасралтгүй ажиллах хугацаа биш юм. Хөрс хуулалт хийх 5, 6-р саруудад ажилласан бөгөөд нүүрс олборлолт явагдах 9-н сарын 15-аас дараа оны 4 сар хүртэл нүүрс гаргалтын үед л ажиллаж байгаа юм. Тиймээс хуурай халуун, хөрс хуулалтын үе давхцах 5, 6-р саруудад уурхайгаас гарах тоос, агаарын бохирдлын хэмжээ бусад үеэс давах бөгөөд энэ үед уурхайн зам талбай, овоолгыг байнга услаж, чийгтэй байлгаж ажилласан.

Тур болон байнгын барилга, байгууламж:

- Үржил шимт хөрсний овоолго
- Хоосон чулуулгийн овоолго
- Уурхайн карьер
- Үерийн усны хамгаалалтын далан /ус зайлуулах суваг/
- Ажилчдын байр, гуанз
- Агуулах сав, ёмкость 6-20 тн.
- Уурхайгаас гарах нүүрс тээвэрлэлтийг хэмжих зориулалт бүхий пүүний (жин) хэсэг

Уурхайн сөрөг нөлөөлөлтэй тэмцэхийн тулд :

- а. Нүүрсний өөрөө шаталтыг анхаарах,
- б. Ачих, буулгах үеийн тоосжилтыг бууруулах,
- в. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, арга хэмжээнүүдийг цогцоор нь шийдвэрлэн ажиллаж байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд 2022 онд 5.5 сая төгрөг төсөвлөснөөс 4.29 сая төгрөг зарцуулан ажилласан.

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол улсын нутаг дэвсгэр дээр байгалийн нөөц баялаг ашиглаж буй аливаа байгууллага аж ахуйн нэгж, иргэд нь тухайн үйл ажиллагааны улмаас үүсэх байгалийн төлөв байдлын эвдрэл, өөрчлөлтийг нөхөн сэргээх талаар Монгол улсын холбогдох хууль, эрх зүйн актуудад хуульчлан заасан байдаг.

Чандганы нүүрсний уурхай нь нийт 43,75 га талбайг хамрах бөгөөд 2012 онд “Абсолютмайнинг” ХХК-ийн гүйцэтгэсэн ТЭЗҮ-д тусгагдсанаар уг уурхайн талбайн гүнзгийрэлт гүйцэт явагдаж дуусаагүй, мөн Уурхайн ашиглалтын явцад уурхайн үйл

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

ажиллагааны улмаас эвдэрсэн газарт уул-техникийн нөхөн сэргээлт хийж, техникийн нөхөн сэргээлтээр овоолгын зарим хэсгийг орчны байдалтай нь зохицуулан хэлбэршүүлж, биологийн нөхөн сэргээлт хийж, ургамалжуулах боловч төслийн талбай нөөц шавхагдаагүй, цаашид ашиглах их хэмжээний нөөц уурхайн ухааш дор, усанд эзлэгдэн байгаа тул зөвхөн шимт хөрс хуулах, хадгалах ажлыг гүйцэтгэсэн ба бусад техник болоод биологийн нөхөн сэргээлтийн ажилд хөрөнгө төвлөрүүлэн сан үүсгээд явж байна. Гэхдээ 1.2 га-д гадаргуугийн эвдрэлтэй хэсэгт талбайг тэгшилж техникийн нөхөн сэргээлт хийгдсэн.

2022 онд 0.44 га талбайд шимт хөрс хуулж, 0.2 га талбайд хэлбэржүүлэлт хийн хадгалан, нийт 0.84 сая төгрөг зарцуулан ажилласан.

2022 оны төлөвлөлтөөр нөхөн сэргээлтийн тусгай санд 6 сая төгрөг байршуулахаар төлөвлөсөн энэхүү мөнгөнөөс одоогоор 1сая-г байршуулсан байгаа тайлант он дуусахаас өмнө үлдэгдэл 5сая төгрөгийг тухайн санд байршуулах юм.

**ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Чандганы нүүрсний уурхай нь нийт 43,75 га талбайг хамрах бөгөөд 2012 онд “Абсолютмайнинг” ХХК-ийн гүйцэтгэсэн ТЭЗҮ-д тусгагдсанаар уг уурхайн талбайн гүнзгийрэлт гүйцэт явагдаж дуусаагүй, мөн Уурхайн ашиглалтын явцад уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт уул-техникийн нөхөн сэргээлт хийж, техникийн нөхөн сэргээлтээр овоолгын зарим хэсгийг орчны байдалтай нь зохицуулан хэлбэршүүлж, биологийн нөхөн сэргээлт хийж, ургамалжуулах боловч төслийн талбай нөөц шавхагдаагүй, цаашид ашиглах их хэмжээний нөөц уурхайн ухааш дор, усанд эзлэгдэн байгаа тул төслийн хэмжээнд зөвхөн шимт хөрс хуулах, хадгалах ажлыг гүйцэтгэсэн ба бусад техник болоод биологийн нөхөн сэргээлтийн ажилд хөрөнгө төвлөрүүлэн сан үүсгээд явж байгаа. 2021 онд тус санд нийт 8сая төгрөг байршуулсан. Энэ жил нөхөн сэргээлтийн ажилд бсая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн ба энэ мөнгийг тайлант онд багтааж байршуулна.

“Говьхангайн төгөл” ХХК-ийн гүйцэтгэж буй БОНБНҮнэлгээний нэмэлт тодотголд тусгагдсанаар Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд манай компани Мөрөн сумын засаг даргын 2018.10.08-ны өдрийн №169 дугаар саналын дагуу Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Мөрөн сумын төвлөрсөн хогын цэгийг төсөл хэрэгжих хугацаанд /5 жилийн хугацаанд/ цэгцэлж, булшилж, тэмдэгжүүлэн хүлээлгэн өгөхөөр тохирсон гэрээний үүргийн дагуу энэ жил 2-3 га газар хогны төвлөрсөн цэгийн хогийг цэвэрлэн булж орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгсөн. Үүнийг гүйцэтгэхдээ нийт 3 хүн, 3 техник хэрэгсэлтэйгээр 6 өдөр ажилласан болно. Энэ ажлыг цаашид

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

2022 он хүртэл үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. Мөн нэмээд 2021 болон 2022 Сумын удирдлагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу сумын төв доторх элс цэвэрлэж зөөх ажлыг хийж эхэлсэн ба 2021 нийт 4 хүн 4-н техниктэй 2-3 өдөр ажилласан байдаг. Үргэлжлүүлээд 2022 оны 06 сард Мөрөн сумын төв доторх элс цэвэрлэж, ачиж зөөсөн. Энэ ажлийн хүрээнд нийт 1.87сая төгрөг зарцуулсан болно.



Сумын төв доторх элс цэвэрлэж байгаа нь 2022 оны 06 өдрүүдэд

4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн ойр орчимд амьдарч байгаа малчдын тоог гаргахаар төлөвлөсөн. Энэ ажлын хүрээнд уурхайгаас 4-5км радиус газарт нийтдээ 8 айлын өвөлжөө бууц байгааг тогтоолоо. Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд 0.6сая төгрөг зарцуулсан болно. Гэвч уурхайн ашиглалтын явцад уурхайн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, айл өрхийн хэмжээнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй шаардлага гарвал тухай бүр хэрэгжүүлэн ажиллана гэж төлөвлөсөн. Одоогоор уурхайн ашиглалтын явцад нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй шаардлага гараагүй тул энэ ажлын хүрээнд ямар нэгэн ажил хийгдээгүй.

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэ ажлын хүрээнд ямар нэгэн ажил төлөвлөөгүй боловч уурхайн ашиглалтын явцад түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллана гэж тусгасан боловч одоогоор түүх соёлын дурсгалт зүйлс илрээгүй.

6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэ ажлын хүрээнд ослын үеийн удирдлага зохион байгуулалтын талаарх сургалтыг тодорхой давтамжтайгаар өгөх байдлаар төлөвлөлт хийгдсэн байсан хэдий ч хөрс хуулалт болон нүүрс олборлолтын үед одоог хүртэл нэг ч осол, эрсдэлгүй амжилттай ажиллаж байна. COVID-2019 цар тахлын хүрээнд ажилчдын амьдрах байр болоод ажлын байр ахуйн эргэн тойронд ариутгал халдваргүйжүүлэлт 3 удаа хийж ажилласан. Мөн цар тахлаас урьдчилан сэргийлэх, арга хэмжээний хүрээнд байгууллагын зүгээс сумын эрүүл мэндийн газарт 25ширхэг түргэвчилсэн оношлуур, 25 ширхэг хамгаалах хэрэгслийн хувцасны хандив тусламж үзүүлсэн.

7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэ ажлын хүрээнд 2022 онд 0.7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 0.9 сая төгрөг зарцуулан ажилласан. Мөн уурхайн талбай түүний ойр орчмын хогны цэг дээр амьтан тэжээл хайж ирэх, орогнох, үүрлэх нөхцөл үүсгэхгүй байх, хог хаягдлаас мал амьтан хордож болзошгүй учир үүнээс сэргийлж хог хаягдлыг удаан хугацаагаар хадгалан хуримтлал үүсгэхгүй цаг тухай бүрд нь ангилан зориулалтын битүү саванд хийж Мөрөн сумтай хийсэн гэрээний дагуу тодорхой хугацаанд ачуулан хогны төвлөрсөн цэгт аваачиж хаяж байсан.

Ахуйн хатуу хог хаягдал:

Ахуйн хог хаягдал нь ерөнхийдөө хүнсний хаягдал, хүнсний боолт баглаа байх ба зарим хувь нь шатахуун ба тосны хаягдал байна. Эдгээрийн ихэнх нь биологийн замаар задрах ба бусдыг нь идэвхигүй гэж үзэж болно. Ажлын байрнаас гарах хогийг түүний ойролцоо байх хогийн саванд хийж байнга цэвэрлэн цуглуулсан. Уг хог хаягдлыг булах байгууламжийг ашиглах зөвшөөрлийг БОЯ-аас гарсан журам заавар болон хог хаягдлын аж ахуйн менежментийн гарын авлагын дагуу зохион байгуулсан. Цаашид мөн хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.

Ахуйн гаралтай хог хаягдал:

Талбайд хийгдэх хэвийн үйл ажиллагааны явцад хортой хог хаягдал үүсдэг, эдгээр хортой хог хаягдлын тоонд ахуйн цэвэрлэгээний материал, цавуу, цемент, уусгагчид болон

хий шахсан үнэртүүлэгчийн сав зэрэг орж байна. Эдгээрийг хадгалах тохиромжтой саванд хийж хадгалах ба хог хаягдлын талбайруу ачихаас өмнө ялгаж тусгаарлаж ажилласан. Ямар төрлийн хог хаягдал байгаль орчинд хор нөлөөлөлтэй ба нөлөөлөлгүй байх талаар ажиллагсадын дунд сургалт зохион явуулсан. Мөн эмнэлгийн зориулалтаар ашигласан эм болон бусад хаягдлыг зөвшөөрөгдөх тусгай уутанд хийж цуглуулан зөвшөөрөгдсөн эмнэлгийн хог хаягдлын устгал хийх газарт устгаж байна.

Үйлдвэрийн хатуу хог хаягдал:

Хаягдал металл болон бусад тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги, хаягдал материалыг цуглуулж ангилан ялгалт хийж, бага хэмжээний металл хогийг хаягдлын талбайд аваачиж хаясан. Засварын газраас гарах хаягдалд аккумулятор, дугуй, тос маслын үлдэгдэл, хаягдал металл болон уусгагчид орсон болно. Засварын газраас гарах тостой хог хаягдалд тосолгооны материал, моторын тос, хөдөлгүүрийн тос, цэвэрлэгээний уусмал, тос болон бусад өдөр тутмын үзлэг тосолгооноос гарсан хаягдлуудыг хэрэггүй болсон шүүлтүүрийг булж хаяхаас өмнө ашиглаж байгаа тосны саванд хатааж дараа хаясан. Тос болон тосолгооны материалаас учрах бохирдуулах хоёрдогч бүтээгдэхүүнийг дахин ашиглах эсвэл гадагшлуулан хаях (хэрэв зөвхөн тунадас үлдсэн бол) мөн шатааж (их хэмжээний тос болон тосолгооны хаягдал) болно. Одоогоор их хэмжээний үйлдвэрийн хатуу хог хаягдал гараагүй байна.

ШИНГЭН ХАЯГДАЛ: Ахуйн шингэн хаягдал: Уурхайд ажиллагсадын бие засах хэсэг болон гал тогооноос ахуйн хаягдал ус гардаг. Шингэн хаягдлыг тусгай бэлтгэсэн нүхэнд хаяхын зэрэгцээ бие засах газар байршуулж хаясан. Ахуйн бохир усыг бохир усны цооногт цуглуулна. Бохир ус хадгалах цооног нь “ахуйн бохир усны цооногийг доторлох ашиглах журам”-ын (БО-ны, ЭМ-ийн сайдын 1995 оны 169/171 дүгээр тушаалын хавсралт) шаардлагыг хангасан байхаар засварлаж тэмдэг, тэмдэглэгээг хийсэн.

Хийн хаягдал: Уурхайн үйл ажиллагааны явцад зохион байгуулалттайгаар агаарын орчинд их хэмжээний хаягдал гаргаагүй боловч уулын хүнд техник, автомашинаас дотоод шаталтын утаа бохирдол гарсан. Мөн байгаль цаг уурын нөхцөл байдалтай уялдан уурхайн орчинд тоосжилт үүсч байгаа эсэхийг ЦУОШГ-ын шинжилгээнд хамруулж, байх ёстой стандарт хэмжээнээс хэтрэлттэй үгүйг тодорхойлуулсан.

8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад жилд нэг удаа тайлагнан байгаль орчныг хамгаалах талаар сургалт семинар зохион байгуулдаг.

2022 онд мөн энэ ажлын хүрээнд 500.0 мян.төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байснаас 900.0 мян.төгрөг зарцуулан ажилласан. Өмнө бид танилцуулга хийхдээ багийн иргэдийн нийтийн хурал цуглаан дээр танилцуулга хийдэг байсан бол 2022 онд ковид-19 цар тахлын тархалт, ахуйн хүрээний ханиад томуу дэгдэхээс сэргийлж, халвдар хамгаалалын дэглэм баримталж айл өрхүүдээр гэрээр явах, утсаар холбогдох байдлаар санал солилцож мэдээлэл хүргэсэн билээ.

Байгаль орчныг хамгаалах удирдлагын систем:

Уурхайн ашиглалтын ажлыг Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай болон Газрын хэвлий, Ашигт малтмалын тухай хуульд болон бусад хууль тогтоомжийн дагуу явуулж, Байгаль орчныг нарийвчилсан үнэлгээний шаардлага зөвлөмж, техник эдийн засгийн үндэслэлийг удирдлага болгон уулын ажлын өрнөлттэй уялдуулан жил бүр төлөвлөн мөрдөж байна.

Уурхайн ашиглалтын хугацаанд байгаль орчин, экологийн үйл ажиллагааг Монгол улсын хууль тогтоомж, дагаж мөрдөх стандартуудыг үндэс болгон ажиллаж байна.

- Газрын тухай хууль, 1995, 2005 онд шинэчлэгдсэн
- Газрын доорхи баялгын тухай хууль, 1994, 1997 онд шинэчлэгдсэн
- Ашигт малтмалын тухай хууль, 2006 онд шинэчлэгдсэн
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
- Усны тухай хууль, 1995 он
- Агаарын тухай хууль, 1995 он
- Ойн тухай хууль, 1995 он
- Ан агнуурын тухай хууль, 1995 он
- Байгалийн ургамлын тухай хууль, 1995 он
- Хортой химийн бодисоос хамгаалах тухай хууль, 1995 он
- Хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 1998 он
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 1995 он
- Ус ба рашаан ус ашигласны төлбөрийн тухай хууль, 1995 он
- Ой, түлшний мод ашигласны төлбөрийн тухай хууль, 1995 он

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

- Ойн түймрээс сэргийлэх тухай хууль, 1996 он
- Ус ба хүрээлэн буй орчны хяналтын тухай хууль, 1997 он

Байгаль орчныг хамгаалахтай холбоотой стандарт, зааварчилгаа болон дүрэм журамууд, үүнд:

- Ундны усны стандарт ба түүнд тавигдах шаардлага УСТ-900-92
- Хот суурин газарт байх тоосжилтын зөвшөөрөгдөх хэмжээ (Эрүүл ахуй Улсын ерөнхий байцаагчийн 1998 оны 11 тоот тушаалын хавсралт №2)
- Тоосжилт ба химийн бодисын ууршилтын хэмжээ УСТ-12-013-91 (MNS)
- Агаарын чанарын үзүүлэлтүүд MNS-4585:98
- Агаарын найрлага: ерөнхий ойлголт, хэмжих нэгж MNS ISO 4226:2000
- Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн үндсэн шаардлагууд УСТ-17.5.1.19-92
- Байгаль орчин, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5914:2008
- Байгаль орчин, уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5915:2008
- Байгаль орчин, газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008
- Байгаль орчин, уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008

Ундны усны эх үүсвэрийг хамгаалах эрүүл ахуйн нөхцлийн дүрэм, байгаль орчны ба дэд бүтэц, эрүүл мэндийн сайд нарын хамтарсан 1995 оны №167 335/а-171 тоот тушаалын хавсралт №1.

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Хүснэгт № 3. Гол нөлөөллийг хамрах хүрээ, эрчим, хугацаа

№	Нөлөөллийн голлох хүчин зүйл	Нөлөөлөлд өртөх орчин, объект	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1	Хөрс хуулалт	Хөрс, ургамлан нөмрөг	Уурхайн эдэлбэрт	Дунд	Удаан хугацаагаар
		Агаар	Уурхайн орчим	Хүчтэй	Богино хугацаагаар
		Хөрсний ус	Уурхайн эдэлбэрт	Хүчтэй	Удаан хугацаагаар
		Гадаргын ус	Хэрлэн гол	Дунд	Богино хугацаагаар
2	Нүүрс олборлолт	Агаар, гадаргын болон хөрсний ус	Уурхайн эдэлбэрт	Хүчтэй	Урт хугацаагаар
3	Шүүрлийн ус	Хөрсний болон гүний ус	Уурхайн эдэлбэрт	Дунд зэрэг	Урт хугацаагаар
4	Доргио дуу, чимээ	Хүн ам, зэрлэг ан амьтан	Ажиллагсад, нутгийн ан амьтан, шувууд	Дунд зэрэг	Урт хугацаагаар

2022 онд орчны хяналт мониторинг, нөлөөллийг бууруулах арга хэмжээнд 1.46 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байснаас 0.84 сая төгрөг зарцуулан ажилласан.

Агаарын бохирдлыг багасгах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:

- Уурхайн бүсэд агаар бохирдуулах гол эх үүсвэрүүдэд нь дараах хүчин зүйлс орно. Үүнд:
- Уурхай дахь машин механизмын үүсгэж буй хөрсний болон нүүрс ачих буулгах үеийн тоос дэгдэлт
 - Уурын зуухны утаа, тортог
 - Дотоод шаталтат хөдөлгүүрийн утаа зэрэг хүчин зүйлүүд ордог учир карьерын орчим, овоолго, тээврийн замын хажууд зэрэг 3 цэгээс агаарын тоосжилтын шинжилгээг тодорхойлуулан дүгнэлт гаргуулан ажилласан. Шинжилгээний хариуг тайланд хавсаргав.

Хөрсийг хамгаалах чиглэлээр жил бүр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Газар ашиглалт, хөрсийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээ нь хөрс хөндөгдөн эвдрэл, доройтолд орох явдлыг багасгахад чиглэгдэж байна. Газар, хөрсний эвдрэл доройтлын үндсэн шалтгаан нь уурхайн карьер, малталтууд, овоолгууд, туслах байгууламжууд болон зам харгуй юм.

Уурхайн ажлын явцад хөрс хуулалтын ажлыг технологийн дагуу явуулсан. Ойр орчины хөрсний эвдрэлээс сэргийлэх зорилгоор ногоон байгууламжийг уурхайн эргэн тойронд үргэлжлүүлэн байгуулсаар байна.

Хүнд машин механизм нүүрс болон хөрс шороог зөөхдөө техникийн зураглалын дагуу гүйцэтгэж, заасан замаар явж байна. Автомашин явах зам, зогсох талбайг нарийн тогтоож тэмдэгжүүлэхийн зэрэгцээ олон салаа зам үүсэхээс сэргийлж, уурхайн орчмын замын сүлжээг оновчтой зохион байгуулж, ашиглалтын зурагт тусгагдсанаас бусад газраар явах, ухаж сэндийлэхгүй байх зэрэг арга хэмжээнүүдийг авч ажилласан.

Хөрс хамгааллын талаар нөлөөлөлд өртөөгүй талбай, шимт хөрсний овоолгоос жилд 2 удаа 2 цэгээс хөрсний ялзмагын агууламж, давсжилт, чийгшил, нийт азот, нийт фосфор, шатахуун ачих буулгах болон машинуудыг шатахуунаар цэнэглэх талбай, засварын талбайн орчим, жилд нэг цэгээс нефть, нефтийн бүтээгдэхүүн, хүнд металлын агууламж, микробиологийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулан дүгнэлт гаргуулан ажилласан. Хөрсний шинжилгээний хариуг тайланд хавсаргав.

Газрын гадарга болон гүний усыг бохирдуулахгүй байх чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээнүүд:

Уурхайгаас гарах шүүрлийн ус, талбайн ойр орчмын гадаргын ус, уурхайн кемпийн унд ахуйн уснаас зэргээс 3 сорьц авч гол ионы найрлага-анион, катион, микро, элементийн агууламж, химийн ба биологийн хэрэгцээт хүчилтөрөгчийг тодорхойлуулан дүгнэлт гаргуулан ажилласан. Шинжилгээний хариуг тайланд хавсаргав.

Ургамлан нөмрөг, амьтны аймаг хамгаалах чиглэлээр:

Нийт тусгай зөвшөөрлийн талбай, ил уурхайн орчимд ургамлын төрөл зүйл, ургамлын дундаж өндөр, газрын гадаргуугаас дээшхи биомассыг тодорхойлох зэрэг ургамлын хяналт шинжилгээг мониторингын ажлыг өмнө жил 1 цэгт, амьтны төрөл зүйл, тоо толгой, шилжилт хөдөлгөөн зэрэг амьтны аймгийн судалгааг тус тусад нь төсөл хэрэгжиж буй талбайн газар нутгийн орчимд тодорхойлуулсан юм.

**10. УУРХАЙГ ТОХИЖУУЛАХ, ТОСГОН ОРЧИМД ХИЙГДЭХ АЖИЛ,
ОРОН НУТАГТАЙ ХАМТРАН АЖИЛ ГЭРЭЭНИЙ ДАГУУ ХИЙГДЭХ АЖЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Уурхайг тохижуулах, тосгон орчимд хийгдэх ажил, орон нутагтай хамтран ажиллах гэрээний дагуу Байгаль орчны бохирдолтыг бууруулах, бэлчээрийн доройтолт үүсэхээс сэргийлэх ургамлан нөмрөгийг хамгаалах зорилгоор эзэнгүй хог хаягдлыг жилд хоёр удаа өөрийн хөрөнгө, хүн хүчийг ашиглан цэвэрлэж ажилласан.

Энэ ажлыг 2022 онд 5км*0.2км талбайг өөрийн компанийн 4 хүн, 3 техник, 3 хоног цэвэрлэн 0.9 сая төгрөг зарцуулан ажиллаж, орон нутагт хүлээлгэн өгсөн. Уурхайн орчимд газар тариалан мод усалгаанд ашиглах зориулалттай гүний худаг тохижуулсан. Энэ ажилд 0.2 сая төгрөг зарцуулсан.

Компани нийгмийн хариуцлагын хүрээнд багийн өндөр настан болон гүүртэй 5 иргэнд, Мөрөн сумын хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан, зорилтот бүлэг, өрх толгойлсон иргэдэд зориулж 50тн нүүрс тус тус үнэ төлбөргүй олгосон бөгөөд зорилтот бүлгийн иргэнд зориулж сумын удирдагуудад нэг гэр хүлээлгэн өгөх ажил төлөвлөгөөт онд багтааж гэрийг тусламж болгон хандивлана. Учир 2022 оны эхний хагаст дизель түлшний үнэ огцом нэмэгдсэнээс хамаарч уурхайн хөрс хуулалтын ажил болон бусад ажлууд удааширч компани санхүүгийн хувьд бодит хүндрэлтэй тулгараад байна. Гэхдээ 2021 онд Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан Улс эх орондоо 2030-н он хүртэлх хугацаанд 1тэрбум мод тарих санаачлагад нэгдсэн сумын удирдлагын хүсэлтээр 2021 онд 100ширхэг улиас модны суулгац хандивласан, 2022 онд 350 ширхэг улиас модны суулгац хандивлаж цаашдын мод тариалалт, ургуулалт, арчилгаанд “Бэрх Уул” ХК-ийн удирдлага хамт олны зүгээс хамтарч ажиллана гэдгээ дахин дахин илэрхийлсээр

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

байна. Мөн Сумын удирдлагын хүсэлтээр сумын төвд хуримлагдсан элсийг цэвэрлэж зөөвөрлөсөн тухай мэдээлэлээ дээр дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд оруулсан энэ ажлыг 2022 оны 06 сарын сүүлээр манай компанийн хамт олон 4-н техник хэрэгсэлтэй 3 хоног хийж гүйцэтгэсэн. Мөн хог хаягдлыг цэвэрлэж 3 удаа ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн болно.



Мөрөн сумын удирдлага болон “Бэрх Уул” ХК-ийн удирдлага, хамт олон Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан 1 тэрбум мод тарих үйл ажиллагаанд хамтран нэгдэж төвийн дэргэд 2021 оны намрын мод тарьсны дараах 2021.10.26 мөн 2022 онд 350 ширхэг суулгац сумын төвийн ойн зурвас ургуулах талбайд тариалсан болно.

11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕММЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ:

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоог тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог хууль тогтоомжид заасан хүрээнд аль болох өргөн хүрээнд, тэдэнд ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт болсон. Байгаль орчныг хамгаалах, мэдээллийг түгээх, ажилчдын дунд сургалт явуулах чиглэлээр өнгөрсөн онд нэлээд ажлыг зохион байгуулсан бөгөөд 2022 онд уг ажлыг үргэлжлүүлэн танилцуулга сургалтыг 2 удаа хийж ажиллалаа. Хэнтий аймгийн БОГ-ын улсын байцаагч нартай албан ажлын чиглэлээр байнгын холбоотой ажилладаг бөгөөд цаг тухайд нь зөвлөгөө аван ажилладаг ба Мөрөн сумын БО улсын байцаагч байнгын хяналт тавин ажилласан.

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн хуралд БОМТөлөвлөгөө болон БОМТайлангын талаар орон нутгийн иргэдэд тайлагнан тэдний санал бодлыг дараа дараагын төлөвлөгөө тайланд тусгаж ажилласан. Энэ ажлын хүрээнд 0.3сая төгрөг зарцуулсан болно.

ДҮГНЭЛТ

Чандганы нүүрсний уурхай нь нийт 43,75 га талбайг хамрах бөгөөд 2012 онд “Абсолютмайнинг” ХХК-ийн гүйцэтгэсэн ТЭЗҮ, 2017 онд “Топазиа” ХХК-ийн гүйцэтгэсэн ТЭЗҮ-ний нэмэлт тодотголд тус тус тусгагдсанаар уг уурхайн талбайн гүнзгийрэлт гүйцэт явагдаж дуусаагүй цаашид ашиглалт үргэлжлэн явагдахаар байх тул нөхөн сэргээлтийн ажил бүрэн хэмжээнд хийгдэж эхлээгүй. Энэ жил овоолгын зарим хэсгийг орчны байдалтай нь зохицуулан хэлбэршүүлж техникийн нөхөн сэргээлт хийгдсэн, шимт хөрс хуулах, хадгалах ажлыг гүйцэтгэсэн. Хэдий нөхөн сэргээлтийн ажил цогц хэмжээнд хийгдэж эхлээгүй ч ТЭЗҮ-д тусгаснаар хөрөнгө төвлөрүүлэн сан үүсгээд явж байгаа.2021 онд 8сая төг байршуулсан бол 2022 онд бсая төгрөг байршуулахаар БОМТ-г батлуулсан. Үүнээс 1сая төгрөг тухайн санд байршуулсан байгаа ба 2022 оны 12 сард багтааж 5 сая төгрөг байршуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. Мөн манай компани бэрх хотын ажлын оффис болон өөрийн хамаарал бүхий барилгын ойр орчимоос 2021 оны өвөл 20-30см урттай 2200 ширхэг улиас модны суулгац гар аргаар бэлтгэн Чандганы уурхайн орчимд суулгаж, туршилт хийж үзсэн.Энэхүү улиасны суулгацыг амжилттай туршиж нутагшуулж байгаа ба өмнө жил суулгасан улиасны 84% орчим ургасан тул цаашид бид 2023 оноос сум орон нутгийн айлуудад хашаандаа улиасны суулгац суулгаж ургуулах боломж бүрдүүлэх талаар төлөвлөн ажиллаж байгаа юм. Уг улиасны суулгацыг манай компани бэлтгэн нийлүүлэхээр тооцоолсон. 2022 оны өвөл нийт 2500 улиасны суулгац бэлдэж улмаар уурхайн бүсэд тариалалт хийсэн болно.

2022 онд Чандганы нүүрсний уурхай нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээ, орчны хяналт мониторинг зэрэг ажлуудад нийт 12.06 сая төгрөг зарцуулах төлөвлөгөөтэй байснаас 13.25 сая төгрөг зарцуулан ажилласан. Үүнд:

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд 5.5 сая.төг зарцуулахаас 4.2 сая.төг,
2. Шимт хөрсний хуулалт, хадгалалтад 1.2 сая төгрөг зарцуулахаас 1.82 сая төгрөг,
3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 2.0 сая төгрөг зарцуулахаас 2.87 сая төгрөг,
4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд 0.7сая төгрөг зарцуулахаас 0.9сая төгрөг,
5. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд 600.0 мян.төг зарцуулахаас 600.0 мян.төг,

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

6. Нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах ажлын хүрээнд 500.0 мян.төг зарцуулахаас 500.0 мян.төг,
7. Уурхайн тосгон орчимд хийгдэх ажлын хүрээнд 1 сая төгрөг зарцуулахаас 1.52 сая төгрөг,
8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 1.42 сая төгрөг зарцуулахаас 0.84 сая төгрөгийг тус тус зарцуулан ажилласан.

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

Хүснэгт № 4. Чандганы нүүрсний уурхайн 2022 оны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн гүйцэтгэл

№	Байгаль орныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Төлөвлөсөн зардал, (сая.төг)	Зарцуулсан зардал, (сая.төг)	Тайлбар
1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН					
1.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан					
1.1.1	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлж	Тээвэрлэлт хийх машины хурдыг хязгаарлаж, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, засаж сайжруулсан	0.3	0.3	Агаарын тухай хууль: Агаарын тухай хуулийн 18-р зүйл, MNS 5885:2008 MNS 4585:2007 MNS 5013:2003 MNS 5014:2003
1.1.2.		Агаар дахь SO ₂ , NO ₂ , PM-2.5, PM-10-ийн агууламжийг тодорхойлуулах, хяналт шинжилгээ хийлгэсэн	ОХШ-ны зардлаас		
1.1.3.			0.0	0	
Дүн:			0.3	0.3	
1.2. Усан орчинд үзүүлэх арга хэмжээний тайлан					
1.2.1	Усанд уусгагч бодисыг ил задгай хаяснаас хур тунадасны усаар угаагдан зөөгдөж газар доорхи устай холилдон нийлэх магадлал өндөртэй	Бохир усыг стандартын шаардлага хангасан битүүмжлэл сайтай, ус нэвтрэхгүй бетон доторлогоотой тусгай бохирын цооногт хуримтлуулдаг. Бохирын цооногийн тэмдэг, тэмдэглэгээг сайжруулсан	0.2	0.2	Усны тухай хууль: “Нүхэн жорлон, угаадасны нүх, техникийн шаардлага” MNS 5924:2015

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

1.2.2		Уурхайн карьерт үүссэн нуураас дээж авч шинжилгээнд өгөх замаар тогтмол хяналт тавин ажиллаж байна	ОХШХ-ийн зардлаас		Усны тухай хууль
	Дүн:		0.2	0.2	
1.3. Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэрт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан					
1.3.1.	Нефтийн бүтээгдэхүүн асгарч, орчны хөрс бохирдуулах	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, аюулгүй болгох арга хэмжээ авсан	0.5	0.5	Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль, Газрын тухай хууль
1.3.2.		Засварын талбай, засварын цех болон бусад газруудад хэрэглэсэн тос, цэвэрлэх материалыг хийх тусгай сав байрлуулсан	0.2	0.2	
1.3.3.	Хөрс элэгдэл, эвдрэлд орох, үржил шим чийг буурах, бохирдох, гадаргын болон унаган хэлбэр өөрчлөгдөх	Олон салаа зам хөрс эвдэх аюултайг тооцож замын сүлжээг цэгцтэй болгож үйлдвэрийн технологийн замуудын эхэнд анхааруулах тэмдэг тавьсан	Үйл ажиллагааны зардлаас		MNS 5916:2008
1.3.4.		Уурхайд ажиллах машин болон бусад техникүүдийг шатахуунаар цэнэглэх, урсгал засвар хийхдээ зөвхөн тусгайлан зассан талбайд гүйцэтгэж байна.	0.8	0.6	

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

		Дүн:	1.5	1.3	
1.4. Ургамлын нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан					
1.4.1	Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр ургамлын нөмрөг устахаас хамгаалж	Барилга байгууламж, ажилчдын хотхоны гадна талбайд ногоон байгууламж бий болгох зорилгоор өмнөх жилүүдэд тарьсан улиасны ургалт муутай моднуудыг шинэчлэн сольж, ургалтад нь анхааран ажилласан. 2022 онд 2500ш 20-30см урттай улиасны суулгац бэлдэж 0.3 орчим га-д, өмнө жил суулгасан улиаснаас өсөлт ургалтгүй болсныг ялган авч арчилгаа хийсэн.	3.5	2.7	
1.4.2.	Үйл ажиллагааны нөлөөллөөр зэрлэг амьтад дайжих, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх	Уурхайн талбай түүний ойр орчмын хогны цэг дээр амьтан тэжээл хайж ирэх, орогнох, үүрлэх нөхцөл үүсгэхгүй байх. Хог хаягдлаас мал амьтан хордож болзошгүй учир үүнээс сэргийлж хог хаягдлыг ангилан зориулалтын битүү саванд хадгалан Мөрөн сумтай хийсэн гэрээний дагуу тодорхой хугацаанд ачуулан хогны төвлөрсөн цэгт аваачиж байна.	0.5	0.2	
		Дүн:	4.0	2.9	

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

Дүн:		5.5	4.2	
2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН				
2.1	Чандганы нүүрсний уурхай нь нийт 43,75 га талбайг хамрах бөгөөд 2012 онд “Абсолютмайнинг” ХХК-ийн гүйцэтгэсэн ТЭЗҮ, 2017 онд “Топазиа” ХХК-ийн гүйцэтгэсэн ТЭЗҮ-ний нэмэлт тодотголд тус тус тусгагдсанаар уг уурхайн талбайн гүнзгийрэлт гүйцэт явагдаж дуусаагүй, мөн уурхайн ашиглалтын явцад уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт уул-техникийн нөхөн сэргээлт хийж, техникийн нөхөн сэргээлтээр овоолгын зарим хэсгийг орчны байдалтай нь зохицуулан хэлбэршүүлж, биологийн нөхөн сэргээлт хийж, ургамалжуулах боловч төслийн талбай нөөц шавхагдаагүй, цаашид ашиглах их хэмжээний нөөц уурхайн ухаш дор, усанд эзлэгдэн байгаа тул төслийн хэмжээнд зөвхөн шимт хөрс хуулах, хадгалах ажлыг гүйцэтгэх ба бусад техник болоод биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй боловч хөрөнгө төвлөрүүлэн сан үүсгэж явдаг.2021 онд тус санд 8сая төгрөг байршуулсан.Энэ жил буюу тайлант онд бсая төгрөг байршуулахаас одоогоор 1сая төгрөг байршуулсан үлдэгдэл 5сая төгрөг 12 сард багтаан байршуулахаар төлөвлөн ажиллаж байна.			
2.2	2022 онд 0.4 га-д шимт хөрсийг хуулж, 0.2 га талбайд хураан хэлбэржүүлэлт хийж стандартын дагуу хадгалсан.	1.2	1.82	Хэдийгээр энэ ажилд тодорхой хэмжээний мөнгө зарцуулдаг ч гарсан зардлыг хөрс хуулалтын зардалд тооцдог.
Дүн:		1.2	1.82	
3. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН				
3.1	Биологийн олон янз байдлыг сайжруулах менежментийн арга хэмжээг тодорхойлох	Мөрөн сумын засаг даргын 2018.10.08-ны өдрийн №169 дугаар саналын дагуу Мөрөн сумын төвлөрсөн хогны цэгийг төсөл хэрэгжих хугацаанд /таван жилийн хугацаанд/ цэгцэлж, булшилж хүлээлгэн өгөх гэрээний дагуу 2020 онд 2-3 га газар цэвэрлэж хүлээлгэн өгсөн. /2-р жил/ 2022 оны Байгаль орчны Менежментийн төлөвлөгөөнд	2.0	2.87

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

		Хэнтий аймгийн Байгаль орчны газрын зөвлөмжийн дагуу Мөрөн сумын нутагт байрлах төв замын дэргэд өмнө ухагдсан эвдрэлд орсон газарт хогийн цэг үүссэн байгаа газыг нөхөн сэргээхээр төлөвлөсөн ч Мөрөн сумын удирдлагын хүсэлтийн дагуу сумын төв доторх элсний хуримтлал ачиж зөөж тэгшилсэн болно.Энэ ажлыг уурхайн 4-5 ажилчид 2-3 өдөл 3-н техник хэрэгсэлтэй нийт 1200тн орчим элс зөөж цэвэрлэсэн			
		Дүн:	2.0	2.87	
4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН					
4.1		Уурхайн ашиглалтын явцад нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй шаардлага одоогоор гараагүй байна. Мөн уурхайн эргэн тойронд байрлах малчин өрх тоолох ажил хийгдсэн.Уурхайн орчинд 4орчим км радиуст нийт 8 өрх суурьшиж байна	0.7	0.9	
		Дүн:	-	-	
5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН					
5.1		2022 онд Чандганы нүүрсний уурхайн ойр орчимд түүх соёлын дурсгалт зүйлс илрээгүй.	-	-	

		Дүн:	-	-	
6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН					
6.1	Гал түймрийн осол эрсдэл	<p>Уурхайн нүүрс олборлолт, хөрс хуулалтын ажил гүйцэтгэх цаг хугацаанд уурхайд нүүрс шаталт үүсэх, карьерт гал гарахаас урьдчилан сэргийлж шатах эрсдэлтэй нүүрсний хэсэг хөрс шороогоор булж, мөн зун уурхайн ажилчид амралттай уурхай үйл ажиллагаа явуулаагүй байх хугацаанд байнгын жижүүр ажиллуулж харуул манаач өглөө оройд эргэж, хянаж ажилласан. Ажилчдын амрах байрны өрөө тасалгаа, коридор, гал тогооны тасалгаа болон засварын хэсэг, шатахуун түгээх хэсэг зэрэгт гал унтраах галын хор байрлуулж хэмийн ажиллагаанд хяналт тавьж байсан. Нийт бл 2 ш галын хор авч, 2ш дахин цэнэглүүлж ажиллагааг хэвийн ажиллахад анхаарсан. Зургийг хавсралтаар үзүүлэв. 2022 онд Уурхайн гадгах орчин болон карьер хэсэгт байнгын ажиллагаатай алсаас хянах боломжтой кареруудыг суурилуулж аливаа галын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажил хийсэн.</p>	0.3	0.3	

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

		Байгалийн гамшигт үзэгдэл болоогүй болно.			
6.2	Ахуйн хүрээний осол гэмтэл	Уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг ХАБ дүрэм сахиулж ажиллаж байна. 2022 оны 4-н сард уурхайн 9 ажилтан ХАБ-ын анхан шатны сургалтад 1 өдөр суусан. Мөн компанийн ХАБ хариуцсан ажилтан өглөө бүр уурхайн ажилчдад нярад өгөөд ажилд гаргадаг. Тайлант онд уурхайн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд одоогоор уурхайн үйл ажиллагаатай холбоотой хүний бие, эрүүл мэнд гэмтээгүй, осол болон осолд дөхсөн тохиолдол бүртгэгдээгүй болно.	0.4	0.25	
	Дүн		0.7	0.55	
7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН					
7.1.	Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын нөлөөгөөр хөрс, ус, агаар бохирдох, ажилчдын	Хог хаягдлыг цуглуулах савыг стандартын шаардлага хангасан битүүмж сайтай хийх, ажилчдын байр оффис, агуулах, ШТС зэрэг газарт байрлуулан, засварлаж байна.	0.1	0.2	Хог хаягдлын тухай хууль

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

7.2	эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Төслийн талбайд үүссэн бүх хог хатуу хог хаягдлыг цуглуулах, Мөрөн сумтай хийсэн гэрээний дагуу тодорхой хугацаанд ачуулан хогын төвлөрсөн цэгт хүргэж устгах арга хэмжээг авч ажилласан.	0.3	0.5	
7.3.		Уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа нүхэн жорлонд жил бүр ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэж байна.	0.2	0.1	Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/
7.4.		Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, жилд нэг удаа дахин боловсруулах үйлдвэр рүү тээвэрлэж байна.	0.1	0.1	
Дүн:			0.7	0.9	
8. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН					
8.1	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоог тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог хууль тогтоомжид заасан хүрээнд аль болох өргөн хангах, тэдэнд ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал	0.5	0.5	“Байгаль хамгаалах тухай” хууль, “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10.1 дэхь заалт, БОНХС-ын 2013 оны А-126 тоот тушаал

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

		бодлыг судлан тусгах, танилцуулгыг зохион байгуулан ажилласан.			
	Дүн:		0.5	0.5	
9. УУРХАЙГ ТОХИЖУУЛАХ, ТОСГОН ОРЧИМД ХИЙГДСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН					
9.1	Уурхайн эдэлбэр газрын хог хаягдал	Байгаль орчны бохирдолтыг бууруулах, бэлчээрийн доройтолд үүсэхээс сэргийлэх зорилгоор эзэнгүй хог хаягдлыг жилд 2 удаа уурхайн техник, хүн хүчийг ашиглан цэвэрлэсэн. Мөн уурхайн ойролцоо тариалж буй мод услах зориулалт бүхий худаг тохижуулахад 0.6сая төгрөг зарцуулсан. Өмнө жил хийгдэж байсан пүү (жин) суурилуулах ажил энэ намар үргэлжлүүлэн хийж байгаа. Пүүний дэргэд байр барих ажилд 0.92сая төг зарцуулаад байна.	1.0	1.52	Уурхайгаас засмал зам хүртэлх 5 км ² талбайн цэвэрлэгээг хийж, орон нутагт жил бүр хүлээлгэн өгдөг.
	Дүн:		1.0	1.52	
10. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН					
10.1	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах талаар танилцуулгыг 2022 оны 10-р сард зохион байгуулсан.		0.6	0.6	Мөрөн сумын 5-р багийн дарга болон орон нутгийн малчидтай хамтран ажилласан
	Дүн:		0.6	0.6	

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН					
11.1. Агаарын чанар					
11.1.	Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос (TSP), PM _{2.5} , PM ₁₀ тоосны уналт	1. Карьерын орчинд 2. Овоолгын орчимд 3. Замын хажууд	0.2	0.3	MNS 4585:2007 MNS 3384:1982 MNS 4048:1988 (PM _{2.5} -0.05мг/м ³ PM ₁₀ -0.1мг/м ³)
	Дүн:		0.2	0.3	
11.2. Гадаргын болон газрын доорх ус					
11.2.	Гадаргын болон газрын доорхи усны чанар: Гол ионы найрлага-анион, катион, микро элементийн агууламж. Химийн ба биологийн хэрэгцээт хүчилтөрөгч	1. Уурхайгаас шүүрлийн ус 2. Талбайн ойр орчмын гадаргын ус 3. Уурхайн кемпийн унд ахуйн ус	0.2	0.2	MNS 3934:1986 MNS (ISO) 5667-5:2001-усны чанар-дээжлэлт MNS 900:2010 MNS 6148:2010 MNS 4586:1998
	Дүн:		0.2	0.2	
11.3. Хөрсөн бүрхэвч					
11.3.	Ялзмагийн агууламж, рН, давсжилт, чийгшил, NO ³ -N, P ₂ O ₅ , K ₂ O, рН, нийт азот, нийт фосфор,	1. Нөлөөлөлд өртөөгүй талбай 2. Шимт хөрсний овоолго	0.2	0.2	
11.4	Нефть, нефтийн бүтээгдэхүүн, нүүрстөрөгчид, хүнд	1. Шатахуун ачих, буулгах машин механизмыг шатахуунаар цэнэглэх талбай	0.06	0.06	MNS 5850:2008

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

	металлын агууламж микробиологийн үзүүлэлт	2. Засварын талбай орчимд			
			0.26	0.26	
11.4. Ургамлын нөмрөг, амьтны аймаг					
11.4.	Ургамлын төрөл зүйл, бүрхэц %, бодгалиудын тоо, Ургамлын дундаж өндөр, газрын гадаргуугаас дээших ургамлын биомасс, кг/га. Амьтны төрөл зүйл, тоо толгой, шилжилт хөдөлгөөн	Нийт тусгай зөвшөөрлийн талбайд Ил уурхайн орчимд	0.3	0.4	
	Дүн:		0.3	0.4	
11.5. Цацраг идэвхийн эрсдэлээс сэргийлэх					
11.5.	Цацраг идэвхийн шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториудад өгч шинжлүүлэх	Цөмийн энергийн комиссын 2015.06 дугаар тогтоолын 1-р хавсралт “Цацрагийн аюулгүйн норм”	0.6	0.04	Багаж эвдэрсэн. Засварлах хугацаа тодорхойгүй
			0.6	0.04	
	Дүн:		1.46	0.84	
	НИЙТ ДҮН: (сая.төг)		12.06	13.8	

Бид 2022 онд Чандганы нүүрсний уурхай нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээ, орчны хяналт мониторинг зэрэг ажлуудад нийт 12.06 сая төгрөг зарцуулах төлөвлөгөөтэй байснаас 13.8 сая төгрөгийг зарцуулан ажиллалаа.

“Бэрх-Уул” ХК-ний эзэмшил бүхий “Чандганы” нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл